

I-III/2021


Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 10



Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс

Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 1 дүгээр улиралд 151.8 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх улирлаас 0.8 хувь, өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1. Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100), улирлаар, хувь



Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өсөхөд хуурай замын тээврийн дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 9.0 хувь, агаарын тээврийн дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2.7 хувь, агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагааны дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 3.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 1. Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2021 I-III	2021 I-III	2021 I-III
	2015	2020 I-III	2020 X-XII
	2015=100		
Ерөнхий индекс	151.8	103.0	100.8
Төмөр замын тээвэр	116.1	100.9	100.0
Хуурай замын бусад тээвэр	135.4	109.0	105.0
Усан замын тээвэр	130.4	100.0	100.0
Агаарын тээвэр	211.1	102.7	100.0
Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа	112.8	103.7	102.6
Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа	148.7	103.2	103.2

Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс

Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 1 дүгээр улиралд 115.2 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх улирлаас 3.5 хувь, өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 2. Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100), улирлаар, хувь



Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өсөхөд цахилгаан холбооны дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 4.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 2. Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2021 I-III	2021 I-III	2021 I-III
	2015	2020 I-III	2020 X-XII
	2015=100		
Ерөнхий индекс	115.2	103.5	103.5
Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	101.4	100.0	100.0
Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагаа	113.7	100.0	100.0
Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа	132.3	100.0	100.0
Цахилгаан холбоо	115.4	104.1	104.1
Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа	140.3	100.0	100.0
Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа	101.7	100.0	100.0

Худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс

Худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 1 дүгээр улиралд 118.6 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх улирлаас 4.3 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар буурсан байна.

Зураг 3. Худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100), улирлаар, хувь



Худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар буурахад бөөний худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнэ 4.3 хувиар буурсан нь нөлөөлсөн байна. Худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2021 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлаас 4.3 хувиар өсөхөд бөөний худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнэ 7.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 3. Худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2021 I-III	2021 I-III	2021 I-III
	2015	2020 I-III	2020 X-XII
	2015=100		
Ерөнхий индекс	118.6	94.1	104.3
Бөөний худалдаа	121.6	95.7	107.4
Жижиглэн худалдаа	115.4	92.4	101.1

Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэгчийн үнийн индекс (ҮҮИ): Тухайн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Индексийн жин: Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

Тооцох аргачлал:

ҮҮИ-ийн тооцоонд дараах Ласпейрсийн үнийн индексийг хэрэглэнэ.

$$I_P^L = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

Үүнд:

I_P^L – t тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс

t – тайлант үе

0 – суурь үе

p_t^i – i барааны тайлант үеийн үнэ

p_0^i – i барааны суурь үеийн үнэ

q_0^i – i барааны суурь үеийн худалдан авсан тоо

Эх үүсвэр: ҮСХ, ХУдалдаа, тээвэр, мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ



Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 15

*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Б.Энхтүвшин
Утас : (976-51)-261561*

